

**2017 онд Монгол Улсын төсвийн хөрөнгөөр
санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад
хийсэн товч дүгнэлт**

Гүйцэтгэсэн:

“Үнэн Хатамж ТББ” судлаач Ж.Сайнзаяа

2016 оны 12 дугаар сар

Нээлттэй нийгэм форумаас санхүүжүүлсэн энэхүү товч судалгааны хүрээнд 2017 онд Монгол Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр Монгол Улсын Засгийн Газраас өргөн барьсан төсөл болон УИХ-аар батлагдсан жагсаалтыг харьцуулан дүгнэлт хийлээ.

2017 онд ЗГ-аас хөрөнгө оруулалтын төслүүдийг 3 хэлбэрээр санхүүжүүлэхээр тусгасан. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр,
- Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй,
- Барих шилжүүлэх концессын төрөл.

Барих шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэхээр батлагдсан төслүүдийн тухайд

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх Барих-Шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэхээр ЗГ-аас өргөн барьсан төсвийн төслөөс 3 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг хасан, бусад төсөл арга хэмжээ, барилга байгууламжийг тоо хэмжээ, төсөвт өртгийг хэвээр нь баталсан. Хасагдсан төслүүдийг дурьдвал:

Хүснэгт 1. 2017 онд концессын төрлөөр хэрэгжүүлэх төсвөөс хасагдсан төслүүд

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
I.1.1.12	Сэлэнгэ аймгаар өнгөрөх олон улсын авто замтай холбох 95 км хатуу хучилттай авто зам барих төсөл	2015	2018	95 272.2	28 581.7
I.1.1.13	Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших Төмөртэйн ордоос Ерөө суманд орших “Болд төмөр Ерөө гол ХХК”-н төмөр замын Хандгайт өртөө хүртэлх 33.4 км төмөр замыг ачих, буулгах терминалын хамт барих төсөл	2014	2018	234 307.1	12 674. 6
I.1.1.15	Төрийн тусгай хамгаалалтын газарт материал илрүүлэгч рентген төхөөрөмж нийлүүлэх төсөл	2016	2017	2 630.5	2 630.5
	Нийт дүн			332 209.8	43 886.8

Барих-Шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэхээр ЗГ-аас өргөн барьсан төсвийн төслөөс нийт 332 209.8 сая төгрөгний төсөвт өртөг бүхий 2017 онд санхүүжих 43 886.8 сая төгрөгийн дээр дурдсан 3 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг хасан баталсан./ Барих-Шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэхээр ЗГ-аас өргөн барьсан төсвийн төслөөс 2016 онд эхлэх гэсэн хугацаа бүхий цэцэрлэг, сургуулийн барилгууд, зам гүүрийн ажлууд 2016 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд байгаагүй учир 2016 онд эхлэх боломжгүй, шинээр эхлэж байгаа төсвүүд гэж үзэж байна./

Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүдийн тухайд

Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг УИХ-д ЗГ-аас өргөн барьсан

жагсаалтын дагуу ямар нэг өөрчлөлт оруулалгүй баталсан. Үүнд, 172 794.9 сая төгрөгийн 119 ш төсөл, арга хэмжээ, барилга байгууламж орсон.

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүдийн тухайд

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг батлахад хэд хэдэн өөрчлөлт оржээ. Тухайлбал: Засгийн газраас өргөн барьсан 2017 оны төсвийн төслийг Улсын Их Хурлаас батлахдаа өргөн бариагүй төсөл арга хэмжээ, барилга байгууламж бш, Засгийн газраас өргөн барьсан боловч Их хурлаас хасагдсан 2 төсөл арга хэмжээ барилга байгууламж байна. Нийтдээ 29,816.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээ, барилга байгууламжын 8,473.7 сая төгрөгийн дүнгээр санхүүжилт хасагдсан байна. Жишээлбэл:

- Улаанбаатар хотноо барих 60 ортой геронтологийн төвийн барилгын төсөл 2011 онд эхэлсэн 9,200.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй байсныг 7,392.9 сая төгрөг болгон 1,807.1 сая төгрөгөөр бууруулсан ба 2017 онд санхүүжих дүн 300.0 сая төгрөгийг хэвээр баталсан.
- Завхан аймгийн Улиастай суманд барих 2015 онд эхэлсэн Ахмадын ордны барилга 1,260.0 сая төгрөгийн төсөвт өртөг, 60.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй ЗГ-аас өргөн барьсан бол 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөг, 2.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэйгээр УИХ-аас баталсан байна. Ингэснээр төсөвт өртөг 60.0 сая төгрөг, санхүүжих дүн 57.8 сая төгрөгөөр буурсан.
- Улаанбаатар хотын “Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах ажлын үргэжлэл” төсөл ЗГ-аас өргөн бариагүй УИХ-аас шууд оруулан баталсан, 2014 онд эхэлсэн төсөвт өртөг 22,291.8 сая төгрөгөөс, санхүүжих дүн 7,350.0 сая төгрөг батлагдсан.
- “Монгол улсын хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах” улсын хэмжээнд явагдах төсөл арга хэмжээ 4,600.0 сая төгрөгийн төсөвт өртөг, 2,300.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэйгээр ЗГ-аас өргөн барьсан ба УИХ-аас энэ төслийг хасан баталсан байна.
- 2011 онд эхэлсэн Япон улсын “Өвсний үндэс” хөтөлбөрийн Монголын талын хөрөнгө улсын хэмжээнд 5,500.0 сая төгрөгийн төсөвт өртөг, 626.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэйгээр ЗГ-аас өргөн барьсан бол 6,200.0 сая төгрөгийн төсөвт өртөг, 1,326.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэйгээр УИХ-аас батлан төсөвт өртөг, санхүүжих дүн тус бүр 700.0 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Хүснэгт 2. 2017 оны Төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтын өөрчлөлт

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	ЗГ-аас өргөн барьсан				УИХ-аас баталсан				Өөрчлөлт	
		Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн		
		Эхлэх	Дуусах			Эхлэх	Дуусах				
I	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА										
I.3.1	Улсын Их Хурлын техник, тоног төхөөрөмж /Улаанбаатар/			0	0	2017	2017	1,688.0	1,688.0	+1,688.0	+1,688.0
IV	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД			2,820.8	943.9			2,593.5	824.3	-226,5	-119,6
IV.1.2	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын конторын барилга /Хөвсгөл/	2012	2017	1,095.0	530.5	2012	2017	867.7	410.9	-227,3	-119,6
V	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД										
V.1.1	Гадаад харилцааны яамны Ёслол хүндэтгэлийн өргөөний шинэчлэл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2013	2017	7,500.0	700.0	2013	2017	5,160.0	700.0	-2340.0	0
VII	ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД			24,006.7	7,448.9			23,946.7	7,391.1	-60,0	-57,8
VII.2	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар			10,800.0	2,560.0			10,800.0	2,502.2		-57,8
VII.2.1.2	Ахмадын ордны барилга /Завхан, Улиастай сум/	2015	2017	1,260.0	60.0	2015	2017	1,200.0	2.2	-60,0	-57,8
IX	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД			81,179.4	16,994.0			76,579.4	14,694.0	-4,600,0	-2,300,0
VII.1.17 /Өргөн барихад	Монгол улсын хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах \улсын хэмжээнд\	2012	2018	4.600.0	2.300.0					-4.600.0	-2.300.0
X	БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД			400,809.2	97,243.1			398,908.1	96,307.0	-1,901.1	-936,1
X.1	Боловсрол			229,038.7	68,250.2			228,773.8	68,850.3	-264.9	+600.1
X.1.1.2	Дэлхийн зөн Олон улсын байгууллагын тусламжийн монголын талын хөрөнгө /улсын хэмжээнд/	2010	2018	8,000.0	700.0	2010	2018	8,000.0	1,200.0	0	+500.0

X.1.1.3	Япон Улсын Өвсний үндэс хөтөлбөрийн монголын талын хөрөнгө /улсын хэмжээнд/	2011	2017	5,500.0	626.3	2011	2017	6,200.0	1,326.3	+700.0	+700.0
X.1.1.10	Сургуулийн хичээлийн байр, спорт заалын барилга, 320 суудал /Архангай, Хангай сум/	2013	2017	3,291.7	409.6	2013	2017	2,882.1	94.7	-409,6	-314,9
X.1.1.29	Сургуулийн хичээлийн байрын барилга /Дархан-Уул, Дархан сум, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа сургууль/	2013	2017	3,305.9	479.0	2013	2017	3,241.9	415.0	-64.0	-64.0
X.1.1.39	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо/	2012	2017	1,489.5	389.5	2012	2017	998.2	168.5	-491,3	-221.0
X.2	Соёл			87,972.4	17,649.8			86,336.2	16,113.6	-1636,2	-1536,2
-	Соёлын төвийн барилга, 250суудал /Увс, Зүүнговь/	2016	2017	1,300.0	1,200.0					-1,300.0	-1,200.0
X.2.1.12	Баруун Монголын уламжлалт соёлын төвийн барилга /Увс, Улаангом сум/	2012	2017	3,332.0	1,000.0	2012	2017	2,995.8	663.8	-336,2	-336,2
XI	ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД			167,309.4	29,438.5			167,133.7	29,438.5	-175,7	0
XI.1.1.7	Сумын доторх хатуу хүчилтгай авто зам 3 км /Завхан, Тосонцэнгэл сум/			1,957.7	56.7	2014	2017	1,782.0	56.7	-175,7	0
XII	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД			26,991.6	6,000.0			32,066.3	7,113.0	+5074,7	+1113
XII.1.1	Хөдөө аж ахуйн салбарын болон Малын удмын сангийн цогцолбор барилга, тоног төхөөрөмжийн хамт /Дархан-Уул, Хонгор сум/			26,065.3	5,595.3	2012	2018	23,970.0	5,595.3	-2095,3	0
XII.1.2	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/			-		2011	2017	2,970.0	554.8	+2,970.0	+554.8
XII.1.3	Хүнс, барааны худалдааны төвийн барилга /Хөвсгөл, Мөрөн сум/			-		2012	2017	4,200.0	558.2	+4,200.0	+558.2
XIII	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД			174,614.2	34,318.3			174,407.1	35,918.3	-207,1	+1,600.0
XIII.1.16	Геронтологийн төв, 60 ор /Улаанбаатар/			9,200.0	300.0	2011	2019	7,392.9	300.0	-1807,1	0
XIII.3	III.Тоног төхөөрөмж			8,000.0	8,000.0			9,600.0	9,600.0	+1,600.0	+1,600.0

XIII.3.1	Хавдар судлалын үндэсний төвийн сити томографын аппарат /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/			-		2016	2017	1,600.0	1,600.0	+1,600.0	+1,600.0
XIV	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД			85,600.0	26,369.0			56,191.8	16,909.8	-28,680.2	-9,459.2
	Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц			68,700.0	17,919.0			39,291.8	8,459.8	-29,408.2	-9,459.2
XIV.1.1	Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах ажлын үргэлжлэл /Улаанбаатар/			-		2014	2018	22,291.8	7,350.0	+22,291.8	+7,350.0
XIV.1.2	Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4-35 кВ-ын шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын үргэлжлэл /үлсын хэмжээнд/			-		2014	2018	17,000.0	1,109.8	+17,000.0	+1,109.8
	НИЙТ ДҮН			1,101,314.1	259,126.4			1,071,497.4	250,654.7	-29,816.7	-8473,7

Жич: 11,12-дугаар багана дахь “Өөрчлөлт” гэж заасан хэсэгт “-” тэмдэг нь төсөвт өртөг, санхүүжих дүн хасагдсан ба багассан байдлыг, “+” тэмдэг нь төсөвт өртөг, санхүүжих дүн нэмэгдсэн ба шинээр ЗГ-аас нэмж баталсан гэснийг, “0” нь уг дүн өөрчлөгдөөгүй гэсэн үг болно.

УИХ-ын даргын багцын УИХ-ын тоног төхөөрөмжийг шинэчлэх 1,688 сая төгрөгийг төслийг Засгийн газраас өргөн бариагүй, төслийн хэлэлцүүлгүүдэд байгаагүй, ба Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцад байх тоног төхөөрөмж шинэчлэх ажил давхардахаар харагдаж байна.

Хүснэгт 3. Тоног төхөөрөмжийн шинэчлэл

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
I.3.1	Улсын Их Хурлын техник, тоног төхөөрөмж /Улаанбаатар/	2017	2017	1,688.0	1,688.0
III.2.2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын тоног төхөөрөмж ажлын үлдэгдэл, Төрийн ордны тохижилт, их засварын ажил /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2016	2017	3,565.0	2,200.0

Батлагдсан төсвөөс харахад зардал хэмнэсэн байдал харагдахгүй байна. 2017 оны улсын төсөв цомхон, шинээр барилга байгууламж, төсөл эхлээгүй боловч эзэн, байршил тодорхойгүй улсын

хэмжээнд, орон нутагт гэсэн бүрхэг заалттай 22 төсөл арга хэмжээ, барилга байгууламж тусгагдсан байна. Жишээлбэл:

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын тоног төхөөрөмж ажлын үлдэгдэл, аймаг, сумдад хийгдэх их засвар /улсын хэмжээнд/ гэсэн 135.0 сая төгрөгийн төсөл тодорхой аймаг, сумын нэр заагаагүй байна.
- Цэвэр, бохир усны итгэмжлэгдсэн болон зөөврийн лаборатори байгуулах /орон нутагт/ гэсэн 2013 онд эхэлсэн, 948.8 сая төгрөгийн төсөвт өртөг, 100.0 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий төсөл аймаг, сум заагаагүй, тодорхой бус байна.
- Түүх, соёлын дурсгалт өвийг дэмжих хөрөнгө оруулалтын 2011 онд эхэлсэн 11,900.0 сая төгрөгийн төсөвт өртөг, 1,950.0 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий төсөл нь тодорхойгүй байна. Түүх, соёлын дурсгалт өвийг дэмжих хөрөнгө оруулалт хийж байгаа нь сайшаалтай хэрэг боловч, санхүүгийн хүндрэлтэй үед юунд зарцуулагдах нь тодорхойгүй төслүүд байгаа нь харамсалтай.

Хүснэгт 4. Нэр, хүчин чадал, байршил тодорхойгүй төслүүд

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
III.2.1	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын тоног төхөөрөмж ажлын үлдэгдэл, аймаг, сумдад хийгдэх их засвар /улсын хэмжээнд/	2016	2017	135.0	135.0
IV.1.3	Хот суурин газрын ус хангамж, гидрогеологийн зураглалын судалгаа	2015	2017	1,000.0	216.6
VII.3.2.1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын их засвар /улсын хэмжээнд/	2017	2017	2,000.0	2,000.0
IX.1.2	Аймаг, сум, суурин газрын нутаг дэвсгэрт газар хөдлөлийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажил /аймаг дундын/	2012	2017	2,997.7	495.5
IX.1.5	Хаягийн мэдээллийн систем байгуулах /улсын хэмжээнд/	2013	2017	3,000.0	1,389.7
IX.1.6	Нийслэл, аймгийн төв, улсын чанартай авто замын дагуух Монгол Улсын иргэнд өмчлүүлэх боломжтой газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, байр зүйн зураглал, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах /улсын хэмжээнд/	2013	2017	4,780.0	1,208.1
IX.1.8	Газрын кадастрын мэдээллийн санг геодезийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх /улсын хэмжээнд/	2013	2017	9,000.0	2,513.8
IX.1.13	Өндрийн сүлжээний давтан хэмжилт, 1 дүгээр ангийн нивелирдлэг хийх /улсын хэмжээнд/	2013	2017	1,100.0	990.0
IX.1.16	Цэвэр, бохир усны итгэмжлэгдсэн болон зөөврийн лаборатори байгуулах /орон нутагт/	2013	2018	948.8	100.0

X.1.1.1	Япон Улсын Засгийн газрын тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа сургуулийн барилгын өргөтгөл төслийн монголын талын хөрөнгө /улсын хэмжээнд/	2006	2017	6,300.0	721.6
X.1.1.2	Дэлхийн зөн Олон улсын байгууллагын тусламжийн монголын талын хөрөнгө /улсын хэмжээнд/	2010	2018	8,000.0	1,200.0
X.1.1.3	Япон Улсын Өвсний үндэс хөтөлбөрийн монголын талын хөрөнгө /улсын хэмжээнд/	2011	2017	6,200.0	1,326.3
X.1.1.4	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Дээд боловсролын шинэчлэл төслийн монголын талын хөрөнгө /улсын хэмжээнд/	2012	2018	30,677.2	2,426.3
X.1.1.41	Япон Улсын Засгийн газрын төслийн бус буцалтгүй тусламжийн монголын талын хөрөнгө /улсын хэмжээнд/	2016	2018	2,400.0	800.0
X.1.1.55	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас олгосон буцалтгүй тусламжийн монголын талын хөрөнгө /1 цэцэрлэг, 21 сургууль/	2016	2017	1,000.0	800.0
X.1.2.1	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /улсын хэмжээнд/	2017	2018	10,550.0	5,550.0
X.1.3.1	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/	2017	2017	10,000.0	10,000.0
X.2.1.1	Түүх, соёлын дурсгалт өвийг дэмжих хөрөнгө оруулалт	2011	2018	11,900.0	1,950.0
XIII.2.1	Эрүүл мэндийн салбарын их засвар /улсын хэмжээнд/	2017	2017	3,000.0	3,000.0
XIII.3.2	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/	2017	2017	8,000.0	8,000.0
XIV.1.1	Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах ажлын үргэлжлэл /Улаанбаатар/	2014	2018	22,291.8	7,350.0
XIV.1.2	Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сүмдын 0.4-35 кВ-ын шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын үргэлжлэл /улсын хэмжээнд/	2014	2018	17,000.0	1,109.8
XIV.2.1	Эрчим хүчний дулааны төв магистраль шугамын шинэчлэлт, их засвар, өргөтгөл /Улаанбаатар/	2017	2018	6,300.0	5,000.0

Эдгээрийг харахад 2017 оны улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ барилга байгууламжийг нарийвчлан тусгаж, илүү тодорхой болгох хэрэгтэй байна.

Зарим олон жил дамжсан төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн хөрөнгө оруулалт бүтнээрээ гараад дууссан ч барилга нь дуусаагүй, тасраад, эсвэл санхүүжилтийг жил алгасч төлөвлөлтөд оруулдаг гэх мэт байдлыг нарийвчлан шалгах шаардлагатай байна.